

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

2025 оны 12 дугаар сарын 18

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК нь Хүний нөөцийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж тайлант онд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна.

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын статус Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 37 дугаартай тогтоолоор Хувьцаат компани болон өөрчлөгдөж, бүтэц орон тоо, албан хаагчдын бүрэлдэхүүн шинэчлэгдсэн. Шинээр 13 иргэнийг сонгон шалгаруулж, ажлын байраар ханган ажилласан. Ажлын байранд томилогдсон албан хаагчид ХК-ийн Гүйцэтэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан Албан тушаалын тодорхойлолтын чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Сул орон тоон дээр нөхөн бүрдүүлэлт хийснээр Магистр 4, Бакалавр зэрэгтэй 8, үүнээс Инженер 6, Хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжилтэй 7 ажилтан ажиллаж эхэлснээс хувийн шалтгаанаар 4 ажилтан үүрэгт ажлаас чөлөөлөгдөн хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотод шилжин суурьшсан. Улмаар сонгон шалгаруулалтаар дахин нөхөн бүрдүүлэлт хийн чиг үүргийн давхардал хийдэлгүй ажиллаж байна.

Хүний нөөцийн холбогдолтой мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас (baganuur-itр.mn) болон “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” фэйсбүүк хуудсанд тус тус байршуулж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар:

1. Ажилтан сонгон шалгаруулах зар
2. Хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөний мэдээ
3. Ажилтны ажлын гүйцэтгэл дүгнэх журам
4. Байгууллагад иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг тус тус байршуулав.

Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаартай Захирамж болон Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт улирал тутамд хүргүүлэн тайлагнаж байна.

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БЯМБАЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАДААД ХАРИЛЦАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХДУЛАМ

